

Энд хөдөлмөр эрхэлж олсон орлогоосоо тодорхой хувийг Монголд суугаа гэр бүл, төрөл садан руугаа амьжиргааны зардал болгон илгээж , тэжээн асардаг иргэд их байдаг гэдэгт эргэлзэхгүй байна.Иймд та бүхэнд тун хэрэг болохуйц нэгэн таатай мэдээг хүргэхийг зорьлоо.


“扶養控除制度” буюу хэрвээ танд тэжээн асардаг хүн байгаа бол таны орлогоос тэжээгчийн хөнгөлөлт/суутгал бодон хасч хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт эдлэх бололцоотой билээ.

Энэ хөнгөлөлтийг эдэлснээр таны цалингаас хасагдах татварын хэмжээ багасах буюу нэг үгээр хэлбэл татварын зардлаа хэмнэх боломжтой юм.Хамгийн таатай нь таны асран, тэжээдэг хүн Япон улсад байхгүй байсан ч та энэ хөнгөлөлтийг эдлэх боломжтой.

Иймд та бүхэн энэхүү татварын хөнгөлөлтийн системийг заавал ашиглаад үзээрэй.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорх Япон текстийн дагуу цахим хуудаснаас хайх болон доор байрлах зурагнаас харна уу.

Хайх: 国税庁 国外居住親族に係る扶養控除等の適用について



Япон улсад ажиллаж амьдардаг Монгол улсын иргэдээ Тэжээгчийн суутгалаа тооцуулж татварын хөнгөлөлт эдэлцгээ




Та суутгалын системд хамрагдаснаар цалингаасаа суутгагдах татварын хэмжээг бууруулах боломжтой.

Тус системд хамрагдахын тулд дараах бичиг баримтуудыг цалин олгогчид бүрдүүлэн өгнө үү.

[Суутгалын төрөл]

- Тэжээгчийн суутгал (Нэг амьжиргаа, өрхийн тооцоотой хүн байвал авах боломжтой суутгал)
- Гэрлэгсэдийн суутгал (Эхнэр, нөхөр байгаа бол авах боломжтой суутгал)

Төрөл садангийн хамрах хүрээ



[Шаардлагатай бичиг баримт]

(1) Төрөл садантай холбоотой бичиг баримт: Засгийн газар, орон нутгийн засаг захиргаанаас гаргасан дараахь бичиг баримтууд:

Гэр бүлийн бүртгэлийн хуулбар, төрсний гэрчилгээ, гэрлэлтийн гэрчилгээ. (Төрөл садны овог нэр, төрсөн он сар өдөр, хаяг эсвэл оршин суугаа газар нь тэмдэглэгдсэн бичиг) Япон хэл дээр давхар орчуулагдсан байх шаардлагатай.

(2) Мөнгө шилжүүлэхтэй холбоотой бичиг баримт: Таны зүгээс оршин суугч бус төрөл садандаа мөнгө төлсөн болохыг нотлох баримтууд. Жишээлбэл, санхүүгийн байгууллагаас гаргасан гадаадын мөнгөн гуйвуулгын хүсэлтийн маягтын хуулбар, эсвэл Мөнгөн гуйвуулгын компаниас гаргасан мөнгөн гуйвуулгын баримт гэх мэт. Япон хэл дээр давхар орчуулагдсан байх шаардлагатай.

[Шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн өгөх хугацаа]

- Ажилд орох үед эсвэл мэдүүлэхийг хүссэн үедээ - **Жин** эцсийн татварын зохицуулалт хийх үеэр (年末調整 10-12 сар)

[Анхааруулга]

"Төрөл садангийн холбоо тэдгээртэй хамааралтай бичиг баримтын тухай"

- Гадаадын засгийн газар эсвэл гадаадын орон нутгийн олон нийтийн байгууллагаас гаргасан бичиг баримтад гэр бүлийн бүртгэлийн хуулбар, төрсний гэрчилгээ, гэрлэлтийн гэрчилгээ гэх мэт бичиг баримтууд багтана.
- Нэг бичиг баримтаар оршин суугч бус төрөл садангийн овог, нэр, төрсөн он сар өдөр, оршин суугаа газрын хаяг зэрэг тэмдэглэгдээгүй байх эсвэл таны хамаатан мөн эсэхийг нотлох боломжгүй тохиолдолд та хэд хэдэн бичиг баримтыг нэгтгэн нотлох хэрэгтэй болно.
- Тэжээгчийн суутгал авах боломжтой буюу тэжээгчийн асрамжид багтах төрөл саданд 6-р ургийн үе доторх цусан төрлийн хамаатан, Эхнэр эсвэл Нөхөр, 3-р ургийн үе доторх гэрлэгсэдийн төрөл садангууд орно.

"Мөнгө шилжүүлэгтэй холбоотой бичиг баримтын тухай"

- Мөнгөн гуйвуулгатай холбоотой бичигт баримтад дараах бичгүүд хамаарна. Хэрэв танил зэргээрээ дамжуулан амьжиргааны зардлаа оршин суугч бус төрөл садандаа бэлнээр өгсөн тохиолдолд танд мөнгө шилжүүлсэн бичиг баримт үлдэхгүй тул тэжээгчийн суутгалд хамрагдах боломжгүй. Анхаарал болгоомжтой байна уу.

① Гадаадын мөнгөн гуйвуулгын хүсэлтийн маягтын хуулбар

Тухайн жилд илгээсэн гадаад гуйвуулгын хүсэлтийн маягтын хуулбартай байх шаардлагатай.

② Зээлийн картын гүйлгээний хуулга

- I. Зээлийн картын гүйлгээний тус хуулга нь та зээлийн картан компанитай гэрээ байгуулсан, оршин суугч бус төрөл садан нь ашиглах зорилгоор авсан зээлийн карт бөгөөд картан төлбөрийг та төлөх нөхцөлтэй (Гэр бүлийн карт гэж нэрлэгддэг) картан гүйлгээний хуулгыг хэлнэ. Энэ тохиолдолд гүйлгээний хуулгыг гэр бүлийн карт эзэмшигчийн оршин суугч бус хамаатан садныхаа мөнгөн шилжүүлэгтэй холбоотой бичиг баримт гэж тооцно.
- II. Зээлийн картан гүйлгээний хуулга нь зээлийн карт ашигласан огноонд харьяалагдах жилийн мөнгөн шилжүүлэгтэй холбоотой бичиг баримт болно.

- Хэрэв оршин суугч бус хэд хэдэн төрөл садний тухайд тэжээгчийн суутгал авах бол төрөл садан бүрт мөнгө илгээх шаардлагатай. Жишээлбэл гэрлэгсэд болон хүүхэд нь оршин суугч бус төрөл саданд багтах тохиолдолд амьжиргааны зардлыг гэрлэгсэд илгээсэн тохиолдолд мөнгөн гуйвуулгатай холбоотой баримт бичиг нь гэрлэгсэдтэй холбоотой мөнгөн шилжүүлгийн бичиг баримтад тооцогдох хэдий ч хүүхэдтэй холбоотой мөнгөн шилжүүлгийн бичиг баримтад багтахгүй.
- Мөнгөн шилжүүлэгтэй холбоотой бичиг баримтын тухайд Тэжээгчийн суутгалд хамрагдах тухайн жилд мөнгө шилжүүлсэн бүх бичиг баримтыг ирүүлэх шаардлагатай. Гэхдээ ижил оршин суугч бус төрөл садандаа жилд 3-аас дээш удаа мөнгө шилжүүлэх бол жилийн эхэн болон сүүлд хийсэн шилжүүлгийн бичиг баримтыг ирүүлснээр та мөнгө шилжүүлэхтэй холбоотой бусад баримт бичгийг ирүүлэхгүйгээр алгасах боломжтой. Энэ тохиолдолд ирүүлээгүй орхисон мөнгөн шилжүүлгийн бичиг баримтыг хадгалах шаардлагатай.

※Энэхүү баримт бичгийг 2015 оны 10-р сард Үндэсний татварын газраас зарласан агуулгад үндэслэн боловсруулсан болно.



TRADE & DEVELOPMENT BANK

モンゴル貿易開発銀行東京駐在員事務所